

## САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

20..... оны .... сарын

Дугаар

Улаанбаатар хот

....- ны өдөр

Энэхүү гэрээг нэг талаас ...../Регистрийн дугаар/ Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: ...../цаашид “Нийлүүлэгч” гэх/,

нөгөө талаас “.....” ХХК /цаашид “Компани” гэх/ хамтран

ажиллахаар харилцан тохиролцож, нийлүүлэгчээс санал болгож буй эд хөрөнгийг Компани худалдан авч, иргэд, хуулийн этгээдэд санхүүгийн түрээсээр түрээслүүлэх зорилгоор байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Нийлүүлэгч нь Компанид эд хөрөнгө худалдах, Компани нь уг худалдан авсан эд хөрөнгө /цаашид “түрээсийн зүйл” гэх/-ийг иргэд, хуулийн этгээдэд санхүүгийн түрээсээр түрээслүүлэх эрх, үүрэгтэйгээр оролцож буй харилцаа болон энэ харилцаанд үндэслэн энэхүү гэрээний тал биш боловч гуравдагч этгээд буюу Түрээслэгч нь / цаашид”Түрээслэгч “ гэх / Нийлүүлэгчээс шаардах эрх үүсэх харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлно.
- 1.2. Компани болон Түрээслэгчийн хооронд үүссэн харилцааг тэдгээрийн хооронд байгуулсан санхүүгийн түрээсийн гэрээгээр зохицуулна.
- 1.3. ....

### ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Нийлүүлэгч дараахь эрх эдэлнэ:
  - 2.1.1. Нийлүүлэгчийн баталгаат хуудас олгогдоогүй бараа болон Түрээслэгчид хүлээлгэн өгснөөс хойш үүссэн барааны дагалдах зүйлд учирсан гэмтэл, эвдрэлийг Нийлүүлэгч хариуцахгүй ба хуучин машинд аливаа засварын баталгаа гаргахгүй;
  - 2.1.2. Барааны нэхэмжлэх бичиж өгснөөс хойш Түрээслэгч барааг авалгүй 2 хоног өнгөрвөл тухайн барааг худалдан борлуулах;
  - 2.1.3. ....
- 2.2. Нийлүүлэгч дараахь үүрэг хүлээнэ.
  - 2.2.1. Компанитай харилцан тохиролцсоны үндсэн дээр өөрийн худалдаа, үйлчилгээний танхимд уг бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах материалыг олон нийтэд харагдахуйц газарт байрлуулах, тайлбарлан таниулах;
  - 2.2.2. Нийлүүлэгч нь Компанийн санхүүгийн түрээсийн үйлчилгээний талаар сонирхсон иргэд, хуулийн этгээдэд тайлбарлан сурталчилж, эд хөрөнгө түрээслэх сонирхол бүхий этгээдэд сонгосон эд хөрөнгийн үнийн жагсаалтыг гарган өгч Компанид хандахыг зөвлөх;
  - 2.2.3. ....



2.3. Компани дараахь эрх эдэлнэ:

2.3.1. Компани нь түрээсийн зүйлийн засвар үйлчилгээ, түрээсийн зүйлийн доголдол зэргийн талаар нийлүүлэгч болон түрээслэгчийн хооронд үүссэн аливаа маргаантай асуудлыг хариуцахгүй;

2.3.2. Нийлүүлэгч энэхүү гэрээний 2.1.15-д заасан үүргээ зөрчсөн нь нотлогдвол гэрээг цуцлах;

2.3.3. ....

2.4. Компани дараахь үүрэг хүлээнэ:

2.4.1. Түрээслүүлэх эд хөрөнгийг Түрээслэгчид хүлээлгэн өгөхийг зөвшөөрсөн мэдэгдлийг бичиж өгөх эрх бүхий ажилтны гарын үсэг, тэмдгийн загварыг Нийлүүлэгчид урьдчилан хүргүүлэх;

2.4.2. Нийлүүлэгчийн ажилтнуудад эд хөрөнгө түрээслэх журам, Түрээслэгчид тавих шаардлагын талаар танилцуулж, шаардлагатай мэдээллээр хангах;

2.4.3. ....

*Үргэлжлэл бий .... /7х/*